ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 23 өдөр Дугаар А/77 Мандалговь

## Сургалт явуулах тухай

Монгол Улсын “Цэргийн албаны тухай хууль”-ийн 33 дугаар зүйл, “Дайчилгааны тухай хууль”-ийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 230 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2017 оны н/03, ЗХЖШ-ын 2017 оны н/22 албан тоот, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Цэргийн штабын “Үндсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу ДБНБ-ний I зэргийн бэлтгэл үүрэгтэй 40 хүний сургалтыг Зэвсэгт хүчний 167 дугаар анги, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн 2017 оны 06 дүгээр сарын 02-ноос 06 дугаар сарын 12-ны өдрийг дуустал 10 хоногийн хугацаатайгаар явуулсугай.

Хоёр. Дээрх 40 хүнийг хооллохын тулд Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 103 дугаар тогтоолын дагуу хүнсний хангамжийн хоногийн хэмжээг 40 хүнээр тооцож, шаардагдах хөрөнгө, сургалтанд шаардагдах бусад зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Тус арга хэмжээнд шаардагдах 4.355.000 /Дөрвөн сая гурван зуун тавин таван мянган/ төгрөгийг Батлан хамгаалах яамнаас оруулсан нэмэлт санхүүжилтийн хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардалаас гарган зарцуулахыг нягтлан бодогч /Ц.Даваа/-д зөвшөөрсүгэй.

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА О.ЧУЛУУНБАТ

0200241

Аймгийн ЗДТГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 23-ны
өдрийн А/77 дугаар тушаалын хавсралт

# 2017 ОНД ДБН-ИЙН I ЗЭРГИЙН БЭЛТЭЛ ҮҮРЭГТЭНТЭЙ ЯВУУЛАХ СУРГАЛТЫН ЗАРДАЛЫН ТООЦОО

| д/д | Хамрагдах хүний тоо | Хугацаа | Байр хоолны зардал | Сургалт тээврийн зардал | Бичиг хэрэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 40 | 10 | 2887200 | 1335400 | 132400 |
| **Бүгд** | | | **4.355.000 ₮** | | |